


Далайн захиргааны даргын 2019 оны 08 дугаар сарын
15-ны өдрийн 65 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



ДАЛАЙН ЗАХИРГААНЫ ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Далайн захиргааны Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орон тооны бус зөвлөлийн зорилго нь /цаашид "Зөвлөл" гэнэ/ байгууллагын түвшинд ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах, эрүүл аюулгүй ажлын байрыг бий болгох, үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, дэмжлэг үзүүлэхэд чиглэгдэнэ.

1.2. Зөвлөлийн үйл ажиллагааны зардлыг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.5.6-д заасны дагуу ажил олгогч хариуцна.

1.3. Зөвлөлийг Зам, тээврийн салбарын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар хороо мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, хамтран ажиллана.

1.4. Зөвлөл нь үйл ажиллагааныхаа талаар захиргаа болон хамт олны өмнө жил бүр тайлагнана.

1.5. Зөвлөл нь үйл ажиллагааны жилийн тайлан, мэдээг Зам, тээврийн салбарын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар хороонд хагас, бүтэн жилийн байдлаар хүргүүлнэ.

Хоёр. Зөвлөлийн удирдлага, бүрэлдэхүүн

2.1. Зөвлөлийг Далайн захиргааны даргын шийдвэрээр байгуулж, татан буулгана.

2.2. Зөвлөлийг Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга ахална.

2.3. Зөвлөл нь 5 хүний бүрэлдэхүүнтэй байна.

2.4. Зөвлөлийн ажиллах журмыг зөвлөлийн хурлаар хэлэлцэн боловсруулж, даргын тушаалаар батлан мөрдөнө.

Гурав. Зөвлөлийн ажлын чиглэл

3.1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомжийн хэрэгжилтийг байгууллагын түвшинд зохион байгуулах;

3.2. Байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хөтөлбөр төлөвлөгөө, төсөвт тусгах асуудлыг боловсруулах, шаардлагатай дүрэм, журмыг баталж, мөрдүүлэхэд санал боловсруулж, батлуулах;

3.3. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн болон үйлдвэрийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчний шалтгаан нөхцөлийн талаар хэлэлцэх, санал, зөвлөмж гаргах;

3.4. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аян, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлаар зөвлөгөөн, сургалт, семинар зохион байгуулах;

3.5. Ажлын байрны эрсдэлийн үнэлгээ хийж, осолд дөхсөн тохиолдлыг илрүүлэхэд оролцох, бүртгэл судалгааг гаргахад дэмжлэг үзүүлэх, удирдлагыг шаардлагатай мэдээллээр хангах;

3.6. Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлд үзлэг шалгалт хийх, дүнг ажил олгогч, ажилтнуудад мэдээлэх;

3.7. Ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслийн хангалт, хэрэглээ, ахуйн байрны орчин нөхцөл, ажилтны хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт, эрүүл мэндийн үзлэгт хамрагдсан байдал, түүний мөрөөр хийгдсэн арга хэмжээтэй танилцах, үр дүнг мэдээлэх;

3.8. Зөвлөл нь Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх орон тооны бус комиссын гишүүдийг чадавхижуулах арга хэмжээг ажил олгогчтой хамтран зохион байгуулах;

3.9. Байгууллагад хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль, тогтоомжийг хэрэгжүүлж байгаа талаар ажил олгогчийн тайлан мэдээллийг зөвлөлийн хурлаар хэлэлцэх, зөвлөмж, шийдвэр гаргах;

3.10. Хууль тогтоомжид заасан бусад асуудал.

Дөрөв. Зөвлөлийн хурал

4.1. Зөвлөл нь байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлаар хэлэлцүүлэг хийх, зөвлөлдөх, зөвлөмж, санал гаргах, шаардлага өгөх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулахад оролцох чиглэлээр ажил олгогч, ажилтны төлөөлөлтэй хамтран ажиллах хэлбэрээр үйл ажиллагаа явуулна.

4.2. Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хурал байна.

4.3. Зөвлөлийн хурлыг нийт гишүүдийн 50-иас дээш хувийн ирцтэй хийнэ.

4.4. Зөвлөлийн хурлыг зөвлөлийн дарга зарлан хуралдуулна.

4.5. Зөвлөлийн хурлаар хэлэлцэх асуудалтай холбогдуулан байгууллагын холбогдох ажилтныг хуралд оролцуулж болно.

4.6. Зөвлөлийн хурлаас шаардлага, зөвлөмж гаргана. Асуудлыг олонхийн саналаар шийдвэрлэж, тэмдэглэл хөтөлнө.